


МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН
ЁСЛОЛЫН БОЛОН АЛБАНЫ ХУВЦАСНЫ ДААВУУНД
ТАВИХ ШААРДЛАГА

MNS 6707 : 2018



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75%-иас доошгүй дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчиллын үндэсний зөвлөл (СҮЗ)-өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш Б.Оюун-эрдэнэ профессор Л.Удвал, “Аюулгүй хөдөлмөрийн үндэс” НҮТББ-ийн зөвлөх, доктор Д.Энхжаргал, Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан А.Ариунбилэг нар боловсруулж, СХЗГ-ын мэргэжилтэн Ч.Пүрэвдулам “Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: “Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандартад нийцүүлэн засварлав.

Уг стандартыг Текстилын техникийн хороогоор хэлэлцэн дэмжсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13348, ШХ-48

Утас: 266754, 263860,

Факс: (976-11) 458032

E-mail: standardinform@masm.gov.mn

Вэб сайт: www.estandart.mn,

www.masm.gov.mn

© СХЗГ, 2018

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 61.020

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёслолын болон албаны хувцасны даавуунд тавих шаардлага	MNS 6707 : 2018
Uniform fabrics for officers National Emergency Management Agency for technical requirements	СТАНДАРТЫН БОЛОВСРУУЛАГЧИД ОЛГОСОН ХУВЬ

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёслолын болон албаны хувцасны гадрын болон дотрын даавууны чанарын үзүүлэлтүүд, түүнд тавих шаардлагыг тогтооход оршино.

Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь ОББ-ын алба хаагчийн ёслолын болон албаны хувцасны гадрын болон дотрын даавууг сонгох, чанарын шаардлагыг тогтоох, шалгахад хамаарна. Тус байгууллагын алба хаагчийн ёслолын болон албаны хувцсанд зориулсан даавууны чанарын үзүүлэлт, шаардлага уг стандартын үзүүлэлттэй тохирсон байна.

Норматив ишлэл

Энэхүү стандартад дараахь иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэсэн бөгөөд иш татсан стандартуудад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг ашиглана. Үүнд:

- ISO 12947-3:2002 Нэхмэл бүтээгдэхүүн. Элэгдэл тэсвэрлэлт тодорхойлох арга
- DIN EN 470/1 Чийг шингээлт тодорхойлох арга
- ISO 12947-3:2002 Нэхмэл бүтээгдэхүүн. Элэгдэл тэсвэрлэлт тодорхойлох арга
- DIN EN 470/1 Чийг шингээлт тодорхойлох арга
- ТМ-10-227 Цэргийн дүрэмт хувцас, гуталны таарамжтай байдал
- ГОСТ 27541-87 Дүрэмт хувцасны зориулалттай нарийн ноосон болон хагас ноосон даавуу. Техникийн нөхцөл
- ГОСТ 27619-88 Цэргийн богино хугацааны алба хаагчдын дүрэмт хувцас. Техникийн шаардлага
- MNS ISO 14184-1-2016 Нэхмэл бүтээгдэхүүн. Формальдегид тодорхойлох усан экстракцын арга
- MNS ISO 105-E01:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг усанд тодорхойлох арга

- MNS ISO 105-E04:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга
- MNS ISO 105-X12:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг үрэлтэнд тодорхойлох арга
- MNS ISO 105-C10:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг угаалганд тодорхойлох арга
- MNS ISO 105-D01:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг хими цэвэрлэгээнд тодорхойлох арга
- MNS ISO 105-X11:2014 Нэхмэл бүтээгдэхүүн. Будгийн тогтворыг индүүдлэгэнд тодорхойлох арга
- MNS 1835-2 :2007 Нэхмэл бүтээгдэхүүн. 1м² жин тодорхойлох
- MNS 1835-3:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга
- MNS 1835-4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга
- MNS 1835-5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац, суналт тодорхойлох арга
- MNS 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тэсвэрлэлт тодорхойлох арга
- MNS 1836-7-2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Бүрзийлт тодорхойлох арга
- MNS 1835-8:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга
- MNS 1835-9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Чийглэг тодорхойлох арга
- MNS 4535:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Агаар нэвтрүүлэлт тодорхойлох арга
- MNS 4010:2009 Нэхмэл бүтээгдэхүүн. Ширхэгтийн бүрэлдэхүүн тодорхойлох арга
- MNS 6295:2011 Нэхмэл. Нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүний аюулгүй байдлын нийтлэг шаардлага
- MNS 6238-2011 Цэргийн алба хаагчдын дүрэмт хувцасны зориулалттай даавуу. Техникийн шаардлага
- MNS 6232-2011 Сурагчийн дүрэмт хувцасны хагас ноосон даавуу. Техникийн шаардлага

3. Нэр томъёо, тодорхойлолт

Стандартад дараах тодорхойлолт бүхий нэр томъёо ашиглагдсан болно.

3.1

ёслолын хувцас

алба хаагч баяр ёслол болон хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох үед өмсөх зориулалттай дүрэмт хувцас;

3.2

албаны хувцас

алба хаагч өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх үед өмсөх зориулалттай дүрэмт хувцас;

3.3

гадрын даавуу

хувцасны загвар, хэв маягыг илэрхийлэх, гадны нөлөөнөөс хамгаалах зориулалт бүхий хувцасны давхаргын хамгийн гадна талын даавуу;

3.4

дотрын даавуу

хувцасны дотор хэсэгт ашиглагдаж байгаа давхаргын даавуу;

3.5

ширхэгт

утас ээрмэл бэлтгэхэд зориулагдсан, хөндлөн огтлолын өчүүхэн бага талбайтай, харьцангуй бат бөх, уян зөөлөн биет;

3.6

байгалийн гаралтай ширхэгт

амьтны болон ургамлын гаралтай түүхий эдээр боловсруулдаг ширхэгт;

3.7

ноосон ширхэгт

амьтны гаралтай түүхий эдээр боловсруулдаг ширхэгт;

3.8

нийлэг ширхэгт

нефтийг дахин боловсруулж нийлэгжүүлэн гаргаж авдаг ширхэгт;

3.9

ширхэгтийн бүрэлдэхүүн

нэхмэлийн бүрэлдэхүүнд байгаа ширхэгтүүдийн эзлэх хувь, %;

3.10

нэг метр квадратын жин

нэгж талбайд ноогдох нэхмэлийн сорьцын жинг 1м² талбайд шилжүүлж тооцсон жин, г/м²;

3.11

нэхээсний нягт

нэхмэлийн 10см-т ноогдож байгаа хөндлөн тууш утасны тоо;

3.12

тасрах үеийн даац

нэхмэлийн сорьцыг тасрах хүртэл зарцуулагдсан хүчний дээд хэмжээ, килограмм хүч ;

3.13

тасрах үеийн харьцангуй суналт

нэхмэлийн сорьцын тасрах үеийн үнэмлэхүй суналт ба анхны уртын харьцаа, %;

3.14

норгосны дараах хэмжээний өөрчлөлт

нэхмэлийг норгосны дараах урт ба өргөний өөрчлөлт, %;

3.15

бүрзийлт

нэхмэлийн гадаргуу дээр ширхэгтийн сул, богино үзүүр бөөгнөрч бөмбөлөг үүсгэх байдал, балл;

3.16**элэгдэл тэсвэрлэлт**

нэхмэлийг зориулалтын төхөөрөмжөөр эргэлдэх хөдөлгөөнөөр үрэхэд бөх бат байдлаа хадгалах чанар, эргэлтийн тоо;

3.17**чийг шингээлт**

нэхмэлийн агаар дах харьцангуй чийгийг шингээх чадвар, %;

3.18**агаар нэвтрүүлэлт**

нэгж хугацаанд нэгж талбайгаар нэвтрэн өнгөрөх агаарын урсгалын хэмжээ, л/цаг/см²;

3.19**хүчил шүлтийн тэнцвэр**

нэхмэлийн усан экстрактын орчны хүчил шүлтийн тэнцвэр, балл;

3.20**формальдегидын агууламж**

нэхмэлийн усан экстрактын орчны хүчил шүлтийн тэнцвэрт 4,8-7,5 нөхцөлд байж болох формальдегидын хэмжээ, мг/ кг;

3.21**будгийн тогтвор**

нэхмэлийн будгийн хөлс, үрэлт, ус, угаалга, индүүдлэг, хими цэвэрлэгээнд тогтвортой байх байдал, балл;

4. Ерөнхий шаардлага

Алба хаагчийн ёслолын болон албаны хувцсыг ерөнхий шаардлагад нийцүүлэн ажиллах орчин, өмсөх нөхцөлд нь тохируулан, батлагдсан эх загвар, техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэлийн зохих технологиор үйлдвэрлэнэ.

Энэхүү стандартын ерөнхий шаардлага нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- 4.1 Ёслол болон албаны хувцасны даавууны өнгөний шийдэл
- 4.2 Ёслол болон албаны хувцасны гадрын болон дотрын даавууны эдэлгээний шаардлага
- 4.3 Үйлдвэрлэгчийн мэдээлэл, хүлээн авах, хадгалах, тээвэрлэх нөхцөл

4.1 Ёслолын болон албаны хувцасны даавууны өнгөний шийдэл

Ёслолын болон албаны хувцасны гадрын даавууны нэр төрөл, өнгө нь батлагдсан загвартай тохирч байна. Алба хаагчийн ёслолын болон албаны хувцасны өнгө нь ажлын байр, албан тушаалаас хамаарахгүйгээр өнгө, өнгөний хосолгоо ижил байна.

Ёслолын болон албаны хувцасны үндсэн гадрын даавууны өнгө нь хөх буюу Pantone 19-4027 /TPX Estate blue/, хосолгоо /хавчуурга/ нь улбар шар буюу Pantone 17-1464 /TPX Red Orange/ өнгөтэй тус тус нийцнэ.

Гадрын даавууны өнгө жигд бус байж болохгүй.

4.2 Ёслолын болон албаны хувцасны гадрын болон дотрын даавууны эдэлгээний шаардлага

4.2.1 Ёслолын болон албаны хувцасны гадрын даавууны бүтцийн шинж чанарын үзүүлэлт 1-р хүснэгтэнд заасан шаардлагыг хангасан байна.

Ёслол болон албаны хувцасны гадрын даавууны бүтцийн шинж чанарын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтийн нэр Хэмжих нэгж	1 дүгээр хүснэгт
		Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн	
	- Ноос, %, багагүй	50.0
	-Полиэстер, %, ихгүй	50.0
2	1м ² -ын жин, г/м ² , багагүй	292.0
3	Зузаан, мм, багагүй	0.47
4	Нэхээсний нягт, тоогоор, багагүй	
	- тууш	270
	- хөндлөн	220

4.2.2 Ёслолын болон албаны хувцасны гадрын даавууны геометрийн шинж чанарын үзүүлэлт 2-р хүснэгтэнд заасан шаардлагад тохирсон байна.

Ёслолын болон албаны хувцасны гадрын даавууны эдэлгээний хугацаанд нөлөөлөх шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	2 дугаар хүснэгт
		Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Даац, кг хүч, багагүй	
	-суурь	110
	-хөндлөн	70
2	Суналт, %, ихгүй	
	-суурь	35
	-хөндлөн	25
3	Бүрзийлт, балл, багагүй	
	Эргэлтийн тоо	
	• 2000	4
	• 5000	4
	• 7000	3
4	Үрэлт тэсвэрлэлт, балл, багагүй	4
5	Гандалт, балл, багагүй	4
6	Будгийн тогтвор, балл	
	• хөлсөнд	5
	• угаалганд	4-5
	• индүүдлэгэнд	5
	• усанд	4
	• хуурай үрэлтэнд	4-5
• хими цэвэрлэгээнд	5	

4.2.3 Ёслолын болон албаны хувцасны гадрын даавууны эрүүл ахуйн шинж чанарын үзүүлэлт 3-р хүснэгт дэх шаардлагад нийцсэн байна.

**Ёслолын болон албаны хувцасны гадрын даавууны эрүүл
ахуйн шинж чанарын үзүүлэлтүүд**

3 дугаар хүснэгт

№	Үзүүлэлтийн нэр	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Агаар нэвтрүүлэлт, багагүй -агаарын эзэлхүүн, л/ цаг/ см ² -агаарын хэмжээ, мм / с	880 330
2	Формальдегидийн агууламж, мг/кг, ихгүй	75

4.2.4 Ёслолын болон албаны хувцасны дотрын даавуунд тавигдах шинж чанарын үзүүлэлт нь 4-р хүснэгт дэх шаардлагад нийцсэн байна.

**Ёслолын болон албаны хувцасны дотрын даавууны бүтцийн
шинж чанарын үзүүлэлтүүд**

4 дүгээр хүснэгт

№	Үзүүлэлтийн нэр	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Гадаргуугийн нягт, г/м ² , багагүй	110
2	Тасралтын ачаалал, Н, багагүй: - суурь - хөндлөн	200 150
3	Чийг шингээх чадвар, %, багагүй	7.0
4	Агаар нэвтрүүлэлт, дм ³ /м ² с, багагүй	100
5	Угаалтын дараах агшилт, суналт, %, ихгүй: - суурь - хөндлөн	-3.0 ±2.0
6	Физик, химийн үйлчлэлд будгийн тогтвор: угаалга, хөлс, хуурай үрэлт, химийн цэвэрлэгээ	Тогтвортой

5. Хүлээн авах, хадгалах, тээвэрлэх нөхцөл

5.1 Мэдээлэл эсвэл зөвлөгөө нь монгол хэл дээр дараах хэлбэрээр өгөгдөнө.

Үүнд:

- Үйлдвэрлэгч байгууллагын нэр буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр болон бүтэн нэр
- Даавууны нэр
- Даавууны өнгө
- Даавууны хэмжээ
- Ширхэгтийн бүрэлдэхүүн
- Хязгаарлагдах нөхцөл /температур, цахилгаан дамжуулалт, химийн бодис гэх мэт/
- Стандартын дугаар
- Үйлдвэрлэсэн огноо

5.2 Хүлээн авах

5.2.1 Ёслол болон албаны хувцасны гадрын, дотрын даавууны чанарыг захиалагч байгууллагын нөхцөл болон энэ стандартад заасан үзүүлэлт, шаардлага, баталсан загварын дагуу шалгаж хүлээн авна.

5.2.2 Даавууг уртын дагуу хуйлан хорхой, шавьжнаас хамгаалах бодис завсар нь хийж, ус, чийг, тоосноос хамгаалсан зориулалтын материалаар ороож битүүмжлээд нэг боодол болгож ирүүлсэн байна.

5.2.3 Даавууны чанарыг хүлээн авах явцад захиалагч, ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагуудын хооронд гарсан маргааныг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

5.3 Хадгалах нөхцөл

5.3.1 Ёслолын болон албаны хувцасны даавууг хорхой шавьж, ус, чийг, тоосноос хамгаалсан зориулалтын материалаар ороож битүүмжлэн, шалнаас 15-аас 20см өндөрлөсөн хөлтэй тавиур дээр хананаас 50см зайд байрлуулж, 60-65 хувийн чийгшилтэй, 16-18⁰С температуртай орчинд хадгална.

5.3.2 Даавууг хадгалах хугацаанаас хамааруулж жилд нэгээс доошгүй удаа хортон шавьжны ариутгал хийнэ.

5.4 Тээвэрлэх нөхцөл

5.4.1 Гадрын болон дотрын даавууг ус, чийг, тоосноос хамгаалсан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.